

# Дэлхийн цэнгэг усны өнөөгийн байдал ба Усан Цахилгаан Станцын далангийн асуудал

Н.Батнасан, усзүйч

Манай дэлхийн 70 хувь нь усаар бүрхэгдсэн хэдий ч зөвхөн 2.5 хувь нь цэнгэг ус юм. Гэвч үүний ихэнхи нь мөнх цас, мөс хэлбэрээр тогтох бөгөөд дөнгөж 0.25 хувь нь ашиглагдах боломжтой билээ.

Түүхийн урт удаан хугацааны туршид байгалийн цэнгэг усны экосистемд хүний үйл ажиллагаа ихээхэн нөлөөлсөөр иржээ. Дэлхийн бараг өнцөг булан бүрт хөдөө аж ахуй, хотжилтийн үсрэнгүй хөгжлөөс хамааран гадрагын болон гүний усны горим доройтсоор байна. Дэлхий нийтээр өсөн нэмэгдэж байгаа хүн амыг цэнгэг ус, хоол хүнсээр хангахын тулд усжуулалттай газар тариалан нэмэгдэж, олон тооны усан сан, далан баригдаж байгаа хэдий ч өнөөдөр дэлхийн хүн амын 40 гаруй хувь нь цэнгэг усаар гачигдсан нөхцөлд амьдарсаар байна. (WRI, 2000). Цаашид, энэ хэмжээ улам өсч 2025 онд дэлхийн хүн амын 2/3 нь ийм нөхцөлд амьдарч болзошгүй байна.

Дэлхийн буурай хөгжилтэй олон орнуудад цэнгэг усны хомсдол нь хүний өвчлөлт болон нас баралтанд нөлөөлөгч үндсэн шалтгааны нэг хэвээр байсаар байна. Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын (WHO) судалгаагаар цаашид бохирдсон уснаас болж дэлхийн 1.2 тэрбум хүний эрүүл мэнд хохирч, улмаар жил тутам 15 сая хүүхэд эндэгдэнэ гэсэн урьдчилсан тооцоо гарчээ (WHO/UNICEF, 2000)

Дэлхийн хэмжээнд цэнгэг усны экосистем ихээхэн доройтсоноос биологийн олон төрөл зүйлүүд цөөрч, зарим нь устахад хүрээд байна. Тухайлбал, цэнгэг уснаас хамаарагч шувуу, загас зэрэг 195 зүйлийн амьтадын тоо 1970-аад оноос 1990-ээд оны сүүл хүртэл 50 гаруй хувиар буурчээ. (C.Revenga and A. Casser, 2002). Гэтэл дэлхийн хүн ам 1990 онд 5.27 тэрбум байснаа 2000 онд 6.06 тэрбум болж даруй 15 хувиар өссөн байна (WHO/UNICEF, 2000). Дэлхийн Цаг уурын Байгууллагын мэдээгээр хүн амын өссөлттэй уялдан усны хэрэглээ 1900-1995 онд 6 дахин өсчээ (WMO, 1997).

Голын гольдролыг хааж боон далан барих нь цэнгэг усны экосистемд ихээхэн нөлөөлдөг хэдий ч түүний хэмжээ 1950 оноос хойш 7 дахин өсч 1970-аад оны үед оргилдоо хүрч өдөрт дэлхийн аль нэг хэсэгт 2-3 далан баригдаж байжээ (WCD, 2000). Ийнхүү усны асар их нөөц бүхий далан олныг барьж цахилгаан энерги, усан хангамж, зам харилцааны зэрэг олон асуудлыг тодорхой түвшинд шийдвэрлэж тухайн улс орны хөгжил дэвшилд чухал үүрэг гүйцэтгэсэн нь мэдээж боловч далан барьснаас үүсэх сөрөг үр дагаврыг олон оронд мэдэрч эхэлсний улмаас сүүлийн жилүүдэд үүнд болгоомжтой хандах болжээ. Далангийн сөрөг үр дагаврыг ийнхүү дэлхий нийт ойлгож, олон хүндрэлтэй асуудалтай тулгарах болсны улмаас 1998 онд “Дэлхийн Далангийн Коммисс” (World Commission on Dams) олон улсын байгууллага үүссэн байна (Интернет хаяг: <http://www.dams.org> ).

Дэлхийн хүн ам үсрэнгүй өсөж байгаатай уялдан цаашид байгалийн хязгаарлагдмал нөөц, баялагийг үр ашигтайгаар, түүний тогтвортой нөхөн сэргээгдэх нөхцлийг ханган ашиглах асуудал чухлаар тавигдаж байна. Ус ашиглалтын байдал, усны хомсдол болон биологийн төрөл, зүйлүүдийн бууралт зэрэг нь өнөөгийн менежментийн арга хэлбэр цаашдын тогтвортой нөхцлийг хангаж чадахгүй болжээ гэдгийг харуулсаар байна. Тиймээс, цаашдын усны хомсдол болон нийгмийн тогтвортой хөгжлийн асуудлыг шийдвэрлэхийн тулд экосистемийг хамгаалах зарчимд тулгуурласан урт хугацааны арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дэлхий нийт эрмэлзэж байна.